



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 9/18

Улаанбаатар хот

Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1629 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 28,750,000 (хорин найман сая долоон зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (М.Мөнхбаатар)-нд зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (М.Мөнхбаатар)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В. Оюумаа В.ОЮУМАА

1150500301



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 05 дугаар сарын 25-ны
өдрийн 17... дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах тээврийн хэрэгсэл

№	Байгууллагын нэр	Автомашин марк, улсын дугаар	Үйлдвэрлэ -сэн он, Монголд ашиглаж эхэлсэн оно	Арлын дугаар	Балансын үнэ	Хуримтлагд -сан элэгдэл	Үлдэх өртөг	Сэлбэг буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах доод үнэ /төгрөг/
1	Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба	Хьюндай Соната-7 01-45УНЧ	2013/2019	КМНЕС4 1LBDA55 3642	15,000,000	6,375,000	8,625,000	500,000
2		Тоёото Клугер 33-45УБУ	2002/2015	ACU2000 30793	6,111,111	6,111,111	0.00	500,000
3		Тоёото Клугер 97-77УБУ	2002/2016	ACU2500 17032	7,638,889	7,638,889	0.00	800,000
Дүн					28,750,000	20,125,000	8,625,000	